



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт

2025 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 99035990 Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитор: Э.Алтансүх

Утас: 91009002 Цахим хаяг: [altansukh@audit.gov.mn](mailto:altansukh@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: [sukhbaatar@audit.gov.mn](mailto:sukhbaatar@audit.gov.mn)

2025.02.25 № 196  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Барилгын ажлын зураг төсөвгүй, зөвшөөрөлгүй барилга байгууламж барихад хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал буюу урсгал төсвөөс 26,659.5 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан, Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж 33,827.5 мянган төгрөгийг өндөр насны тэтгэврээ тогтоолгохоос өмнө нягтлан бодогчид олгосон, автын дадлагын хичээлтэй холбоотой үйлчилгээний 600.0 мянган төгрөгийн орлогыг төсвийн дансаар дамжуулалгүй зарцуулж, 330.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй, биеийн тамирын заал түрээсийн 810.0 мянган төгрөгийн орлогыг биеийн тамирын багш хувийн дансаар авч, байгууллагын төсвийн дансанд төвлөрүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5./хариуцлагатай байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5./батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах./ заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" болон "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

D:\Бичиг хэрэг\2025\Явсан бичиг\A4 тоот 2025.docx

2225020096

Тус аудитаар хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын тооцоолол, зарцуулалттай холбоотой тодорхой асуудлууд хөндөгдсөн. Тухайлбал, мэргэжлийн анги тус бүрийн хувьд нэг суралцагчийн нэгж ур чадварыг эзэмшихэд шаардлагатай материалын тоо, хэмжээг тодорхойлохын тулд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг сургууль, коллежийн сайн туршлагыг судлах, харьцуулах шаардлагатай байна. Мөн дадлагын материалын зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна. Манай дүгнэлтэд нөлөөлөхгүй боловч, энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай тул бид үүнийг онцлон тэмдэглэж байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитаар нийт зарлагын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлж, нөлөө бүхий ажил гүйлгээг нарийвчлан шалгав. Тухайлбал: 8 албан хаагчийн ажилласан хугацааны мөнгөн тэтгэмж 69.5 сая төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж (2 албан хаагч) 49.2 сая төгрөг, барилгын сэндвич хавтан, хоолны тогоо, ухаалаг дэлгэцийн худалдан авалт 29.2 сая төгрөг, дадлагын материал худалдан авсан 4 гүйлгээ 28.3 сая төгрөг, боловсролын магадлан итгэмжлэлийн үнэлгээний 6.5 сая төгрөгийн төлбөр зэрэг ажил гүйлгээнүүдэд нарийвчилсан горим сорил хийж, холбогдох хууль, эрх зүйн үндэслэл, баримтын бүрдэл болон төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нягталсан болно.

#### **Бусад асуудал**

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд шууд нөлөөлөхгүй ч байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт, дотоод хяналтын хүрээнд анхаарах шаардлагатай байна.

1. Сургуулийн өмнөх авто зам дээр хурд сааруулагч хийх зориулалтаар худалдан авсан 4 нэр төрлийн 24 ширхэг, нийт 2.6 сая төгрөгийн материалыг зарцуулаагүй 2 жил дараалан санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнаж, ажлыг хийж гүйцэтгээгүй.

2. Албан томилолтын зардлаас 12.4 сая төгрөгийн томилолтын нөхөх төлбөрийг төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон.

3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг бүрэн мэдээлээгүй, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 196.7 сая төгрөгийн 2 арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 330.5 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square stamp with Mongolian text and a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style and appears to be 'Г. ДАВАА'. The stamp contains the text 'АДБОУС' and other smaller characters.

Г.ДАВАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,900,604.52	248,819,730.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	156,391,102.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	156,391,102.84
3121	Төгрөг	0.00	156,391,102.84
31211	Төрийн сангийн харилцах	0.00	156,391,102.84
33	АВЛАГА	98,782.23	347,282.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	98,782.23	347,282.32
35	БАРАА МАТЕРИАЛ	94,801,822.29	92,081,345.10
354	Хангамжийн материал	94,801,822.29	92,081,345.10
35410	Бичиг хэргийн материал	1,174,500.00	234,000.00
35420	Аж ахуйн материал	6,033,650.00	888,700.00
35450	Барилгын засварын материал	16,014,776.50	13,861,776.50
35460	Хүнсний материал	110,780.79	131,506.60
35470	Бусад хангамжийн материал	71,468,115.00	76,965,362.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	831,994,480.04	918,446,669.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	831,994,480.04	918,446,669.97
392	Биет хөрөнгө	467,289,560.04	543,516,749.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	509,047,369.15	601,810,369.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,800,000.00	36,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	409,347,635.00	447,413,540.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,190,981.04	212,117,501.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,332,640.00	15,052,640.00
39217	Ном	58,922,863.00	63,160,363.00
393	Биет бус хөрөнгө	364,704,920.00	374,929,920.00
39301	Програм хангамж	20,731,475.00	20,731,475.00
39303	Бусад биет бус хөрөнгө	364,704,920.00	374,929,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	926,895,084.56	1,167,266,400.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	4,235,579.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	4,235,579.06
413	Өглөг	0.00	4,235,579.06
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	2,144,179.06
4136	Бусад өглөг	0.00	2,091,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2,091,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	926,895,084.56	1,163,030,821.17
51	Засгийн газрын хувь оролцоо	926,895,084.56	1,163,030,821.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,154,614,547.09	1,164,839,547.09
51101	Өмч: - төрийн	1,154,614,547.09	1,164,839,547.09
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	225,910,736.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,648,522.31	63,648,522.31

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	926,895,084.56	1,167,266,400.23
---	--	----------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,755,902,880.00	2,453,557,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,568,680.00	167,757,520.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,568,680.00	167,757,520.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,568,680.00	167,757,520.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	49,468,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,568,680.00	118,289,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,708,334,200.00	2,285,800,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,460,611,200.00	2,029,449,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,460,611,200.00	2,029,449,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,172,900.00	150,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,964,400.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,208,500.00	150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,550,100.00	256,200,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,550,100.00	256,200,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,742,672,500.97	2,227,647,083.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,742,672,500.97	2,227,647,083.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,783,632.41	2,105,441,183.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,119,133.10	1,323,093,528.04
210101	Үндсэн цалин	579,528,864.93	807,818,256.67
210102	Нэмэгдэл	303,047,581.63	396,588,414.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,606,000.00	54,266,500.00
210104	Урамшуулал	66,936,686.54	64,420,356.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,049,959.74	162,700,611.43
210201	Тэтгэврийн даатгал	84,834,688.04	111,934,895.57
210202	Тэтгэмжийн даатгал	9,974,359.73	13,261,002.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,909,087.40	6,964,778.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,831,587.66	6,015,724.98
210205	Эрүүл мэндийн даатгал	18,500,236.91	24,524,210.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,334,732.87	242,144,579.06
210301	Гэрэл, цахилгаан	12,482,558.74	12,646,891.80
210302	Түлш, халаалт	192,444,634.13	195,402,607.26
210303	Цэвэр, бохир ус	20,407,540.00	34,095,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,174,310.00	26,776,503.00
210401	Бичиг хэрэг	2,342,500.00	6,823,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,550,000.00	4,700,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,915,160.00	3,097,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,663,800.00	2,387,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,702,850.00	9,768,303.00
2105	Нормативт зардал	58,120,752.49	69,103,626.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,968,137.00	761,784.00
210502	Хоол, хүнс	55,152,615.49	68,341,842.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,040,330.00	52,639,740.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,317,600.00	4,680,400.00
210604	Урсгал засвар	29,722,730.00	47,959,340.00
2107	Томилолт, зочны зардал	3,602,600.00	7,271,800.00
210702	Дотоод албан томилолт	3,602,600.00	7,271,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,887,030.00	11,097,665.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,583,550.00	11,026,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,480.00	50,680.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,228,000.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	20,685.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,454,784.21	210,613,130.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,870,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,307,323.61	131,256,865.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,147,460.60	77,485,735.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,888,868.56	122,205,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,747,700.00	122,055,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,498,400.00	49,229,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,499,300.00	69,546,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	3,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,141,168.56	150,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,141,168.56	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,230,379.03	225,910,736.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,230,379.03	225,910,736.61

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,708,334,200.00	2,335,268,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	49,468,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	49,468,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	49,468,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	49,468,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,708,334,200.00	2,285,800,300.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,460,611,200.00	2,029,449,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,460,611,200.00	2,029,449,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,172,900.00	150,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,964,400.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,208,500.00	150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,550,100.00	256,200,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,550,100.00	256,200,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,693,170,200.00	2,143,453,792.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,693,170,200.00	2,143,453,792.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,539,281,331.44	2,021,247,892.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,217,915.33	1,332,153,249.82
210101	Үндсэн цалин	580,019,296.35	772,422,279.03
210102	Нэмэгдэл	302,811,516.59	436,877,355.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,514,000.00	58,930,651.70
210104	Урамшуулал	66,873,102.39	63,922,963.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,049,959.74	153,889,389.74
210201	Тэтгэврийн даатгал	84,835,187.12	104,860,186.49
210202	Тэтгэмжийн даатгал	9,973,860.65	12,357,095.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,909,087.40	6,402,124.38
210204	Ажилгүйдлийн даатгал	1,831,587.66	6,044,579.46
210205	Эрүүл мэндийн даатгал	18,500,236.91	24,225,404.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,334,732.87	240,000,400.00
210301	Гэрэл, цахилгаан	12,482,558.74	12,646,891.80
210302	Түлш, халаалт	192,444,634.13	193,258,428.20
210303	Цэвэр, бохир ус	20,407,540.00	34,095,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,364,710.00	0.00
210401	Бичиг хэрэг	3,298,600.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	2,550,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,915,160.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,671,200.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,929,750.00	0.00
2105	Нормативт зардал	63,248,019.50	68,785,021.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,922,939.00	0.00
210502	Хоол, хүнс	53,733,580.50	68,785,021.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,591,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,575,198.00	30,552,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	840,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,386,800.00	14,352,000.00
210604	Урсгал засвар	38,348,398.00	16,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,602,600.00	0.00

210702	Дотоод албан томилолт	3,602,600.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,392,780.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,709,300.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,480.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,608,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,495,416.00	195,867,831.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	98,598,814.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,495,416.00	97,269,017.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,888,868.56	122,205,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,747,700.00	122,055,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,498,400.00	49,229,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,499,300.00	69,546,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	3,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,141,168.56	150,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,141,168.56	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,164,000.00	191,814,507.84
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,164,000.00	35,423,405.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,164,000.00	35,423,405.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,164,000.00	35,423,405.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,164,000.00	35,423,405.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,164,000.00	-35,423,405.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	156,391,102.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	156,391,102.84

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	70,145,778.58	0.00	70,145,778.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн	0.00	0.00	70,145,778.58	0.00	70,145,778.58

	үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,226,867.28	0.00	5,226,867.28
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	75,372,645.86	0.00	75,372,645.86
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	75,372,645.86	0.00	75,372,645.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	96,999.00	0.00	96,999.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	75,469,644.86	0.00	75,469,644.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	99,472,919.77	0.00	99,472,919.77
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	174,942,564.63	0.00	174,942,564.63

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,061,899,100.00	1,922,526,797.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,061,899,100.00	1,922,526,797.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,939,623,200.00	1,800,470,897.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,358,283,800.00	1,332,153,249.82
210101	Үндсэн цалин	761,012,500.00	772,422,279.03
210102	Нэмэгдэл	514,621,900.00	436,877,355.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,649,400.00	58,930,651.70

210104	Урамшуулал	0.00	63,922,963.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,785,400.00	153,889,389.74
210201	Тэтгэврийн даатгал	115,454,100.00	104,860,186.49
210202	Тэтгэмжийн даатгал	13,582,800.00	12,357,095.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,791,400.00	6,402,124.38
210204	Ажилгүйдлийн даатгал	6,791,400.00	6,044,579.46
210205	Эрүүл мэндийн даатгал	27,165,700.00	24,225,404.16
2105	Нормативт зардал	73,745,000.00	68,785,021.60
210502	Хоол, хүнс	73,745,000.00	68,785,021.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,066,300.00	14,352,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,066,300.00	14,352,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319,742,700.00	231,291,236.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,372,700.00	127,058,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	155,370,000.00	104,233,076.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,275,900.00	122,055,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,275,900.00	122,055,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,229,900.00	49,229,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	69,546,000.00	69,546,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,280,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,061,899,100.00	2,078,917,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,029,449,900.00	2,029,449,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,029,449,900.00	2,029,449,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	32,449,200.00	49,468,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,449,200.00	49,468,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	156,391,102.84
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92,343.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Заал түрээсийн орлоготой холбоотой зөрчилд 810.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, урсгал төсвөөс барилга байгууламж барьсан 46,909.5 мянган төгрөгийн, нэг удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой 33,827.5 мянган төгрөгийн, үйл ажиллагааны орлоготой холбоотой 930.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, шилэн дансны хөтлөлттэй холбоотой өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байсан тул хариуцлага тооцуулах албан шаардлага, бараа материалын үлдэгдэл болон албан томиллолттой холбоотой асуудлаар 9,866.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 92,343.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 26,140.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 66,203.5 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### **3.1. Төлбөрийн акт**

#### **1. Биеийн тамирын заал түрээсийн орлоготой холбоотой**

##### Илрүүлэлт:

Биеийн тамирын заал түрээсийн 810.0 мянган төгрөгийн орлогыг биеийн тамирын багш хувийн дансаар авч, байгууллагын төсвийн дансанд төвлөрүүлээгүй. Энэ нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 (Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.) заалтыг зөрчиж, "нийцсэн бөгөөд зохистой байх" болон "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### Актын товч утга:

Хэн буруутай этгээдээр төлүүлж, 810.0 мянган төгрөгийг хүү, торгуулийн дансанд төвлөрүүлэхийг төсөв захирагч, нягтлан бодогч нарт хариуцуулав.

### **3.2. Албан шаардлага**

#### **1. Урсгал төсвөөс барилга байгууламж барьсан асуудал**

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 26,659.5 мянган төгрөг, АЗДТГ-аас өгсөн 8,200.0 мянган төгрөг, Баруун-Урт сумын ИТХ-аас 2,000.0 мянган төгрөг, материалын хандиваар 5,900.0 мянган төгрөг, багш, ажилчид, суралцагчдаас 4,150.0 мянган төгрөг, нийт 46,909.5 мянган төгрөгийг авто, гагнуурын дадлагын байрны барилгын ажилд зарцуулж, хөрөнгийн үнэлгээний компаниар үнэлүүлж, данс бүртгэлд 92,763.0 мянган төгрөгөөр тусгасан байна. Урсгал төсвөөс хөрөнгийн зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5./батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/ заалтыг зөрчсөн. Мөн тус барилгын ажлыг зураг, төсөлгүй, барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 40.2./Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно./ заалт, 18.1./Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ./ дэх заалтыг тус тус зөрчсөн. Эдгээр нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Албан шаардлагын товч утга:

Урсгал зардлаас хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх, барилга байгууламжийг зураг төсөл, зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байхыг төсөв захирагчид хариуцуулав.

#### **2. Нэг удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой асуудал**

Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламжийг өндөр насны тэтгэврээ тогтоолгохоос өмнө нэг албан хаагчид 33,827.5 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1.1, 2.2 дахь заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Албан шаардлагын товч утга:

Тэтгэвэрт гарч буй албан хаагч тэтгэврээ тогтоолгосон тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгож байх, зөрчлийг давтан гаргахгүй байхыг төсөв захирагчид хариуцуулав.

#### **3. Үйл ажиллагааны орлоготой холбоотой**

Автын дадлагын хичээлд 1,550.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг, эд анги, тос маслод материал зарцуулсан бөгөөд үүнээс албан хаагчдын автомашинд сэлбэг, эд анги, тос маслыг хийсэн тохиолдолд зах зээлийн үнээс 30-40 хувиар бага төлбөр авдаг гэх боловч төсвийн дансанд орлого төвлөрөөгүй, төвлөрвөл зохих 930.0 мянган төгрөгийн орлогоос 600.0 мянган төгрөгийг төсвийн данснаас гадуур сургуулийн үйл ажиллагаанд шууд зарцуулж, 330.0 мянган төгрөгийг аудитын хугацаанд төсвийн дансанд тушаасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.(төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;) дэх заалт, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-ын 2.6 (Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.) заалтыг зөрчиж, "нийцсэн бөгөөд зохистой байх" болон "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Албан шаардлагын товч үтгэ:

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалттай холбоотойгоор үйл ажиллагааны орлого олох тохиолдолд байгууллагын төсвийн дансанд тухай бүр төвлөрүүлэх, хяналт тавих, зөрчлийг давтан гаргахгүй байхыг төсөв захирагчид хариуцуулав.

### **3.3. Хариуцлага тооцуулах албан шаардлага**

#### **1. Шилэн дансны хөтлөлттэй холбоотой**

Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг бүрэн мэдээлээгүй, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 196.7 сая төгрөгийн 2 арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 330.5 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг зөрчсөн бөгөөд өмнөх аудитаар албан шаардлага боловч биелэлт хангалтгүй байна.

Албан шаардлагын товч үтгэ:

Буруутай этгээдэд сахилгын хариуцлага тооцож, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хугацаанд байршуулж байх, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхыг төсөв захирагчид хариуцуулав.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

#### **1. Бараа материалын үлдэгдэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Сургуулийн өмнөх авто зам дээр хурд сааруулагч хийхэд зориулж худалдан авсан 4 нэр төрлийн 24 ширхэг 2,594.8 мянган төгрөгийн материалыг бараа материалын тайланд эхний болон эцсийн үлдэгдлээр тайлагнаж, зарцуулалт хийгээгүй, тухайн ажлыг хийж гүйцэтгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.(төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;) дэх заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургуулийн өмнөх авто зам дээр хурд сааруулагч хийх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран яаралтай зохион байгуулж, бараа материалын үлдэгдэлд байгаа 2,594.8 мянган төгрөгийн материалыг зориулалтын дагуу ашиглаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.

#### **2. Албан томилолтын зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Албан томилолтын зардлаас 7,271.8 мянган төгрөгийн томилолтын нөхөх төлбөрийг төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь /Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална./, 2.6 дахь /Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно./ заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Албан томилолтыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 6 тогтоолын төсөв захирагч шийдвэр гаргаж, томилолтын зардлын 50 хувийг урьдчилан олгож байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн аудитын байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Заал түрээсийн орлоготой холбоотой	1	810.0	1	810.0	-	-	-	-	-	-	-	-	-
Урсгал төсвөөс барилга байгууламж барьсан асуудал	1	46,909.5	-	-	1	46,909.5	-	-	-	-	-	-	-
Нэг удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой	1	33,827.5	-	-	1	33,827.5	-	-	-	-	-	-	-
Үйл ажиллагааны орлоготой холбоотой	1	930.0	-	-	1	930.0	-	-	-	-	-	-	-
Бараа материалын үлдэгдэлтэй холбоотой асуудал	1	2,594.8	-	-	-	-	1	2,594.8	-	-	-	-	-
Дүн	5	85071.8	1	810.0	3	81,667.0	1	2,594.8	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс	
		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Шилэн данстай холбоотой асуудал	1	-	1	1	-	-
Албан томилолтын зардалтай холбоотой	1	7,271.8	-	-	1	7,271.8
Дүн	2	7,271.8	1	1	1	7,271.8